

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /11-р сарын 20-ноос 12-р сарын 18-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	XI/20	XI/27	XII/04	XII/11	XII/18
1	Гурил, I зэрэг, кг	700	700	700	700	700
2	Хонины мах, кг/ ястай/	6000	6000	6000	6000	6000
3	Үхрийн мах, кг /ястай/	7500	7500	7500	7500	7500
4	Ямааны мах /ястай /	5250	5250	5000	5000	5000
5	Элсэн чихэр, кг	1550	1550	1550	1550	1550
6	Цагаан будаа, кг	2100	2100	2100	2100	2100
7	Шингэн сүү, л	1300	1300	1300	1300	1350
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан					
9	- Бор ноолуур					
10	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
11	Бензин, А-92, 1 литр	1650	1650	1650	1650	1650
12	Дизелийн түлш, 1 литр	1750	1750	1750	1750	1750

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2013 оны 11-р сарын 20-ноос 12-р сарын 18-ны хооронд ямааны ястай махны үнэ буурч, шингэн сүүний үнэ өсч өөрчлөгдөв. Бусад бүтээгдэхүүний үнэ тогтвортой байв. Энэ хугацаанд ноолуурын арилжаа хийгдсэнгүй.

Махны үнэ. Хонь, үхрийн ястай мах сүүлийн 5 долоо хоногийн туршид өөрчлөгдөөгүй байна. Ямааны ястай мах 11-р сарын 20-ноос 11-р сарын 27-ныг хүртэл 5250 төгрөгийн ханштай байсан бол 12-р сарын 04-нд 500 төгрөг болж өмнөх хоёр 7 хоногийн ханшаас 4,8%-аар буурч энэ ханш сүүлийн гурван 7 хоногийн турш хадгалагдаж байна.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Сүүлийн 5 долоо хоногийн туршид гурил, элсэн чихэр, цагаан будааны дундаж үнэ тогтвортой байж өөрчлөгдсөнгүй.

Шингэн сүү. Хүйтний улирал ирж буйтай холбоотойгоор шингэн сүүний нийлүүлэлт багасч үнэ нь өсч байна. 11-р сарын 20-ноос 12-р сарын 11-нийг хүртэл 1300 төгрөгийн үнэтэй байсан литр сүү 12-р сарын 18-наас 1350 төгрөг болж 3,8%-аар өсөв.

Түлш шатахуун. Шатахууны үнэ сүүлийн 6 сарын турш тогтвортой байна.



